



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсролын үнэлгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох нийт 65,629,400.00 (жаран таван сая зургаан зуун хорин есөн мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий Тоёото FJ круйзер маркийн, 34-66 УБИ улсын дугаартай суудлын автомашины цаашид ашиглах хугацааг 3 жилээр сунгаж, үнийг 24,375.000.00 (хорин дөрвөн сая гурван зуун далан таван мянган) төгрөгөөр шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000070